

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/356/396

Улаанбаатар хот

Химийн хорт болон аюултай бодисын ангилал батлах тухай

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг 1 дүгээр, Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг ашиглах аргачлалыг 2 дугаар, Химийн хорт болон аюултай бодисын ангилалд хамруулсан бодисын жагсаалтыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Ангилал батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 04/04 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН
ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН
САЙД

Н.БАТЦЭРЭГ

Г.ШИЙЛЭГДАМБА

Байгаль орчин, ногоон хөгжил,
аялал жуулчлалын сайд, Эрүүл
мэнд, спортын сайдын 2015 оны
10 дугаар сарын 08 өдрийн
хамтарсан тушаалын 1
дүгээр хавсралт

Химийн хорт болон аюултай бодисын ангилал

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 4.2 дахь заалтыг үндэслэн, Нэгдсэн үндэсний байгууллагаас боловсруулж гаргасан “Химийн бодисын ангилал, хаягжуулалтын нэгдсэн систем. 2013”-ийг ашиглан боловсруулсан энэхүү жагсаалтыг химийн хорт болон аюултай бодис, хольцыг ангилахад ашиглана.

1.2. Энэхүү жагсаалтын зорилго нь химийн бодисыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хор аюул болон физикийн аюулаар нь ангилж, ангилал тус бүрт тохирсон анхааруулах тэмдэг, дохио үг, аюулын тэмдэглэгээ хэрэглэх замаар химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсадад тухайн бодисын хор аюулын талаарх товч, тодорхой, ойлгомжтой мэдээллийг өгөхөд оршино.

1.3. Химийн хорт болон аюултай бодисыг ангилалд хамруулахад “Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг ашиглах аргачлал”-ыг ашиглана.

1.4. Энэхүү ангилал нь химийн хорт болон аюултай бодисын зөвшөөрөл авах үндэслэл болохгүй.

Хоёр. Хамрах хүрээ

Химийн хорт болон аюултай бодисын ангилал нь:

- эмийн бодис,
- цацраг идэвхт бодис,
- хүнсний зориулалттай бодисоос бусад бүх төрлийн бодис, хольцод хамаарна.

Дөрөв. Химийн хортой бодисын ангилал

Ангилал	Хортой					Арьс үрэвсүүлэгч			Нүд хүчтэй гэмтээгч ба цочроогч бодис			Амьсгалын зам болон арьс мэдрэгжүүлэгч бодис	
Зэрэглэл	Зэрэглэл 1	Зэрэглэл 2	Зэрэглэл 3	Зэрэглэл 4	Зэрэглэл 5				Зэрэглэл 1	Зэрэглэл 2		Зэрэглэл 1	
Дэд зэрэглэл						Дэд зэрэглэл 1A	Дэд зэрэглэл 1B	Дэд зэрэглэл 1C		Зэрэглэл 2/2A	Зэрэглэл 2B	Дэд зэрэглэл 1A	Дэд зэрэглэл 1B

Ангилал	Үр удамд нөлөөлөгч бодис			Хавдар үүсгэгч бодис			Нөхөн үржихүйд хортой бодис			Нэг удаагийн нөлөөллөөр тодорхой эрхтэн системийг хордуулдаг бодис		
Зэрэглэл	Зэрэглэл 1		Зэрэглэл 2	Зэрэглэл 1		Зэрэглэл 2	Зэрэглэл 1		Зэрэглэл 2	Зэрэглэл 1	Зэрэглэл 2	Зэрэглэл 3
Дэд зэрэглэл	Дэд зэрэглэл 1A	Дэд зэрэглэл 1B		Дэд зэрэглэл 1A	Дэд зэрэглэл 1B		Дэд зэрэглэл 1A	Дэд зэрэглэл 1B				

Ангилал	Олон удаагийн давтамжит нөлөөллөөр тодорхой эрхтэн системийг хордуулдаг бодис		Амьсгалахад хортой бодис		Усан орчинд хортой бодис			Озоны давхаргад хортой бодис
Зэрэглэл	Зэрэглэл 1	Зэрэглэл 2	Зэрэглэл 1	Зэрэглэл 2	Зэрэглэл 1	Зэрэглэл 2	Зэрэглэл 3	Зэрэглэл 1

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал
жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын
сайдын 2015 оны 10 дугаар сарын
08-ны өдрийн А/356/396 хамтарсан
тушаалын 2 дугаар хавсралт

**Химийн хорт болон аюултай бодисын
ангиллыг ашиглах аргачлал**

2015

ГАРЧИГ

1. Оршил	3
2. Химийн бодис болон хольцыг ангилах	3
3. Ангиллын хамрах хүрээ	4
4. Нэр томъёоны тайлбар	5
5. Химийн хорт болон аюултай бодисын ангилал	10
5.1 Аюултай бодис	10
5.1.1 Тэсрэмтгий бодис	9
5.1.2 Шатамхай хий	11
5.1.3 Аэрозол	12
5.1.4 Исэлдүүлэгч хий	13
5.1.5 Даралтад савласан хий	13
5.1.6 Шатамхай шингэн	14
5.1.7 Шатамхай хатуу бодис	15
5.1.8 Өөрөө урвалд ордог бодис ба хольц	15
5.1.9 Пирофор шингэн	17
5.1.10 Пирофор хатуу бодис	17
5.1.11 Өөрөө халдаг бодис ба хольц	17
5.1.12 Устай харилцан үйлчлэхэд шатамхай хий ялгаруулдаг бодис ба хольц	18
5.1.13 Исэлдүүлэгч шингэн	19
5.1.14 Исэлдүүлэгч хатуу бодис	19
5.1.15 Органик хэт исэл	20
5.1.16 Металл зэврүүлэгч бодис	21
5.2 Хортой бодис	22
5.2.1 Хортой бодис	22
5.2.2 Арьс үрэвсүүлэгч ба цочроогч	22
5.2.3 Нүд хүчтэй гэмтээгч ба цочроогч бодис	23
5.2.4 Амьсгалын зам болон арьс мэдрэгжүүлэгч бодис	24
5.2.5 Үр удамд нөлөөлөгч бодис	25
5.2.6 Хавдар үүсгэгч бодис	25
5.2.7 Нөхөн үржихүйд хортой бодис	26
5.2.8 Нэг удаагийн нөлөөллөөр тодорхой эрхтэн системийг хордуулдаг бодис	26
5.2.9 Олон удаагийн давтамжит нөлөөллөөр тодорхой эрхтэн системийг хордуулдаг бодис	27
5.2.10 Амьсгалахад хортой бодис	27
5.2.11 Усан орчинд хортой бодис	28
5.2.12 Озоны давхаргад хортой бодис	30
6 Хор аюулын талаарх мэдээлэл	30
6.1 Хор аюулын лавлах мэдээлэл	30
6.2 Шошгожуулалт	33
7 Ангилал болон шошгожуулалтын нэгтгэсэн хүснэгт	37
ХАВСРАЛТ 1	
Аюулын тэмдэглэгээний код	55

ХАВСРАЛТ 2

Сэрэмжлүүлэх тэмдэглэгээний код

60

ОРШИЛ

Шинжлэх ухаан, технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед химийн бодисын нэр төрөл, хэрэгцээ шаардлага жилээс жилд өсөн нэмэгдэж, үүнтэй уялдан химийн бодисоор байгаль орчин бохирдох, хүний эрүүл мэндэд хор нөлөөлөл үзүүлэх тохиолдлууд гарах боллоо. Химийн бодисын зохистой хэрэглээг бий болгож, түүний хор нөлөөллөөс хүний эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахад дэлхийн улс орнууд ихээхэн анхаарал хандуулан, хэд хэдэн гэрээ, конвенцийг гаргаад байна.

Химийн бодисын ашиглалт, тээвэрлэлт, хадгалалтын үеийн аюулгүй ажиллагааг хангах, химийн бодис бүрээр нэгдсэн нэг ойлголттой байх зорилгоор НҮБ-аас 1999 онд “НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж, аргачилсан заавар”, түүний дагалдах боть болох “НҮБ-ын аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж. Туршилт, шалгуурын гарын авлага”, 2003 онд “Химийн бодисын ангилал, хаягжуулалтын нэгдсэн систем”-ийг тус тус батлан гаргасан ба 2013 онд “Химийн бодисын ангилал, хаягжуулалтын нэгдсэн систем”-ийг шинэчлэн гаргасан байна.

Химийн аюулгүй байдлын тухай засгийн газар хоорондын форум, Тогтвортой хөгжлийн тухай дэлхийн дээд хэмжээний уулзалтуудаас “Химийн бодисын ангилал, хаягжуулалтын нэгдсэн систем”-ийг 2008 он гэхэд дэлхий нийтээр мөрдөх зорилтыг тавьсан бөгөөд ингэснээр химийн бодис бүрийг шинж чанар, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөгөөр нь цогц тодорхойлон, ангилалд хамруулж, нэгдсэн, товч, тодорхой хаяг шошгийг ашиглах боломжийг бүрдүүлсэн юм.

Монгол Улсын Их хурлаас 2006 онд батласан “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 4.1-д химийн бодисыг уг ангиллын дагуу хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд үзүүлэх нөлөөллөөр нь хортой ба аюултай гэж ангилахаар заасан билээ.

Дээр дурьдсан баримт бичгүүдэд нийцүүлэн Монгол улсад мөрдөгдөх химийн хорт болон аюултай бодисын ангилал болон уг ангиллыг ашиглахад шаардагдах мэдээлэл, нэр томъёо, тодорхойлолт, тайлбарыг агуулсан аргачлалыг боловсруулан гаргаж байна.

2. ХИМИЙН БОДИС БОЛОН ХОЛЬЦЫГ АНГИЛАХ

Химийн бодисын ангиллын “**химийн бодис**” гэсэн ухагдахуунд зөвхөн химийн элемент, нэгдлүүдээс гадна химийн бодисын хольцыг хамруулна.

Бодис гэж бүтээгдэхүүний тогтвортой байдлыг хангахад шаардлагатай аливаа нэмэлт болон үйлдвэрлэсэн аргаасаа хамаарч аливаа хольцыг агуулсан байгалийн төлөв байдалд байгаа болон үйлдвэрлэлийн аргаар гарган авсан бүх химийн элемент, тэдгээрийн нэгдлүүдийг хэлнэ. Энд бодисын тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр болон түүний бүтцийг өөрчлөхгүйгээр зайлуулж болох аливаа уусгагч хамаарахгүй.

Хольц гэж хоорондоо урвалд ордоггүй хоёр болон түүнээс дээш бодисоос бүрдсэн хатуу бодис эсвэл уусмалыг хэлнэ.

Хольцыг бүрдүүлж буй бодисууд нь нэг ижил шинж чанартай байвал түүнийг нэг төрлийн бодис гэж авч үзэж болно. Жишээлбэл: Нефтийн бүтээгдэхүүний буцлах температур гэх мэт үзүүлэлт нь ижил байдгаас нэг төрлийн бодис гэж үздэг. Ийм бодист нэг бодис гэж үзэн олон улсын бүртгэлийн дугаар (CAS буюу Chemicals Abstract Service) өгдөг байна.

Тухайн бүтээгдэхүүн хэд хэдэн төрлийн химийн нэгдлийг янз бүрийн хэмжээгээр агуулсан байвал хольцыг ангилах аргачлалын дагуу ангилал тогтооно.

Хайли нь хоёр болон түүнээс дээш элементээс тогтсон, механикаар салгах боломжгүй, макро түвшинд нэг төрлийн металлыг үүсгэнэ. Хайлшийг хольц гэж үзнэ.

Зарим химийн бодис нь хор аюул учруулах зөвхөн нэг шинж чанартай байдаг бол зарим бодис хэд хэдэн шинж чанарыг агуулна. Иймээс химийн бодисыг ангилал бүрийн шалгуураар оруулж тухай бодисын хор аюулыг бүрэн гүйцэд таньж, ангилалд хамруулна.

Химийн бодис, материалын хортой болон аюултай шинж чанарыг тодорхойлж, үнэлэлт өгөхийн тулд материалын шинж чанарын талаар хангалттай мэдээлэл цуглуулах, судлах шаардлагатай бөгөөд эдгээр мэдээлэл, өгөгдөхүүнийг хор аюулын шалгуур үзүүлэлттэй харьцуулж ангиллыг тогтооно. Гэхдээ зөвхөн тухайн бодисын шинж чанарыг илэрхийлсэн мэдээлэлд нь үндэслэж ангилах нь учир дутагдалтай байдаг тул мөн төстэй бодистой нь харьцуулах шаардлагатай.

Хольцыг ангилахдаа түүний бүрдэл хэсгүүдийн аюулын зэрэгт үндэслэх ба Нэгдсэн системийн тухайн зэрэглэлд хамааралтай босго хязгаарыг ашиглана. Өөрөөр хэлбэл, хольц нь доорх хүснэгтэд заасан босго хязгаараас их хортой болон аюултай бодис агуулж байвал уг хольцыг тухайн бодисын хамаарах ангилалд хамааруулна.

Эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодисын ангиллын босго хязгаар

Аюулын анги	Босго концентраци
Хортой	≥1,0%
Арьс үрэвсүүлэгч ба цочроогч	≥1,0%
Нүд хүчтэй гэмтээгч ба цочроогч	≥1,0%
Амьсгалын зам болон арьс мэдрэгжүүлэгч	≥0,1%
Үр удамд нөлөөлөгч (Зэрэглэл 1)	≥0,1%
Үр удамд нөлөөлөгч (Зэрэглэл 2)	≥1,0%
Хавдар үүсгэгч	≥0,1%
Нөхөн үржихүйд хортой	≥0,1%
Нэг удаагийн нөлөөллөөр тодорхой эрхтэн системийг хордуулдаг	≥1,0%
Олон удаагийн давтамжит нөлөөллөөр тодорхой эрхтэн системийг хордуулдаг	≥1,0%
Амьсгалахад хортой (Зэрэглэл 1)	зэрэглэл 1-ийн бодис ≥10% ба кинематик зууралданг чанар нь 40°C-д ≤14мм ² /с
Амьсгалахад хортой (Зэрэглэл 2)	зэрэглэл 1-ийн бодис ≥10% ба кинематик зууралданга чанар нь 40°C-д ≤14мм ² /с
Усан орчинд хортой	≥1,0%

3. АНГИЛЛЫН ХАМААРАХ ХҮРЭЭ

Химийн хорт болон аюултай бодисын ангилал нь:

- эмийн бодис

- цацраг идэвхт бодис
- хүнсний зориулалттай бодисоос бусад бүх төрлийн бодист хамаарна.

4. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Амьсгалын зам мэдрэгжүүлэгч бодис - амьсгалснаас амьсгалын замын хэт мэдрэгшил өгдөг бодис.

Анхааруулах тэмдэг – Ямар нэг хор аюулын талаарх мэдээллийг хамгийн товч байдлаар дамжуулах график дүрслэл.

Арьс мэдрэгжүүлэгч бодис - арьстай хүрэлцсэнээс харшил өгдөг бодис.

Арьсны үрэвсэх - 4 цагаас их хугацаагаар туршилтын бодисоор үйлчлэхэд арьсанд нөхөн сэргээгдэхгүй гэмтэл үүсэх.

Арьсны цочролт - 4 цагаас илүүгүй хугацаанд туршилтын бодисоор үйлчлэхэд арьсанд нөхөн сэргээгдэх гэмтэл үүсэх.

Аюулын тэмдэглэгээ - Тухайн аюултай бүтээгдэхүүний хор аюулын шинж чанар, аюулын түвшинг илэрхийлсэн хэллэг.

Бодис - Бүтээгдэхүүний тогтвортой байдлыг хангахад шаардлагатай аливаа нэмэлт болон үйлдвэрлэсэн аргаасаа хамаарч аливаа хольцыг агуулсан бүх байгалийн төлөв байдалд байгаа болон үйлдвэрлэлийн аргаар гарган авсан химийн элемент, тэдгээрийн нэгдлүүд. Энд бодисын тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр болон түүний бүтцийг өөрчлөхгүйгээр зайлуулж болох аливаа уусгагч хамаарахгүй.

Био хуримтлал- Био концентрацийн үзүүлэлт (БКҮ) нь ≤ 500 эсвэл БКҮ нь тогтоогдоогүй боловч $\text{Log } K_{ow} \geq 4$ байх.

Буцлах эхний температур – шингэний уурын даралт нь хэвийн даралттай (101,3 кПа) тэнцүү байх үеийн шингэний температур, өөрөөр хэлбэл, хийн анхны бөмбөлөгүүд бий болох үеийн температур;

Дохио үг – Болзошгүй аюулын тухай урьдчилан анхааруулах, хор, аюулын ноцтой байдлын харьцангуй түвшинг заах зорилгоор хэрэглэдэг үг.

Исэлдүүлэгч шингэн - өөрөө шатамхай бус боловч ихэвчлэн хүчилтөрөгч ялгаруулах замаар гал авалцуулах, эсвэл бусад материалын шаталтыг өдөөх чадвартай шингэн.

Исэлдүүлэгч хатуу бодис - өөрөө шатамхай бус боловч ихэвчлэн хүчилтөрөгч ялгаруулах замаар гал авалцуулах, эсвэл бусад материалын шаталтыг өдөөх чадвартай хатуу бодис.

Исэлдүүлэгч хий – хүчилтөрөгч ялгаруулан агаараас илүүтэйгээр гал авалцуулах, эсвэл бусад материалын шаталтыг өдөөх чадвартай бүх хий.

ХАЛМ- хор аюулын лавлах мэдээлэл.

Металл зэврүүлэгч бодис , хольц - химийн урвалын нөлөөгөөр металлыг мэдэгдэхүйц хэмжээгээр гэмтээдэг эсвэл бүр устгадаг бодис буюу хольц.

Ноцох цэг – шатамхай шингэнээс ялгарсан уур агаарт шатамхай хольц үүсгэж шатах хамгийн бага температур (101,3 кПа стандарт даралтад).

Нөхөн үржихүйд хортой бодис - насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүний нөхөн үржихүйн эрхтний үйл ажиллагаа, үр тогтоох чадвар, мөн түүнчлэн үр хөврөлийн өсөлт хөгжилтөнд нөлөөлөгч бодис.

НҮБ-ын дугаар (UN number) – олон улсын тээвэрлэлтэд ашиглах зорилгоор химийн хорт болон аюултай бодисыг дугаарласан 4 оронтой тоо. Ижил шинж чанартай бүлэг бодисыг нэг дугаараар дугаарласан байж болно.

НҮБ-ын туршилт, шалгуурын гарын авлага - “НҮБ-ын Аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж. Туршилт, шалгуурын гарын авлага” НҮБ (Женев, Нью-Йорк), 1999, 3-р хэвлэл

НҮБ-ын аргачилсан заавар- “НҮБ-ын Аюултай ачаа тээвэрлэх зөвлөмж, аргачилсан заавар” НҮБ (Женев, Нью-Йорк), 1999.

Нүд хүчтэй гэмтэх- туршилтын бодис нүдний гадаад салст бүрхэвчид үйлчилснээс хойш 21 хоногийн дараа бүрэн нөхөн сэргээгдэхгүй нүдний эд гэмтэх, хараа ноцтой муудах.

Нүдний цочрол - туршилтын бодис нүдний гадаад салст бүрхэвчид үйлчилснээс хойш 21 хоногийн дараа бүрэн нөхөн сэргээгдэх өөрчлөлт үүсэх.

НС- химийн бодисын ангилал хаягжуулалтын нэгдсэн систем.

Нэг удаагийн нөлөөллөөр тодорхой эрхтэн системийг хордуулдаг бодис -нэг удаагийн нөлөөллийн үр дүнд тодорхой эрхтэнд үхлийн бус тогтолцооны хордлого өгдөг бодис.

Олон улсын бүртгэлийн дугаар (CAS number) – химийн элемент, нэгдэл, полимер, микроорганизм, хольц болон хайлшийг Химийн асуудлаар тойм бэлтгэх албанаас (CAS) бүртгэж дугаарласан дугаар.

Озон задлах чадвар – Агаарын дээд мандлын озон давхаргыг задлах CFC-11-ийн чадвартай масс-массын харьцаагаар харьцуулсан тухайн галогент нүүрс устөрөгчийн озон задлах чадварын харьцангуй хэмжээ. CFC-11-ийн озон задлах чадварыг 1 гэж үзнэ. Жишээ нь озон задлах чадвар нь 2 байна гэдэг нь CFC-11-ээс 2 дахин аюултай гэж ойлгоно.

Олон удаагийн давтамжит нөлөөллөөр тодорхой эрхтэн системийг хордуулдаг бодис - хэд хэдэн удаагийн давтамжит үйлчлэлээр онцгой өртөмтгий эрхтэн/тогтолцоонд хорт нөлөө учруулдаг бодис.

Органик хэт исэл - нэг, эсвэл хоёр устөрөгчийн атом нь органик радикалаар халагдсан устөрөгчийн хэт ислийн уламжлал гэж үзэж болох, -0-0- гэсэн хоёр валенттай бүлэг агуулсан шингэн, эсвэл хатуу төлөвт байдаг органик бодисуудыг хэлнэ. Органик хэт исэл гэсэн нэр томъёонд органик хэт ислүүдийн хольцыг хамруулдаг.

Өөрөө урвалд ордог бодис ба хольц- хүчилтөрөгчийн (агаарын) оролцоогүй тохиолдолд ч экзотермийн эрчимтэй задралд ордог дулаанд тэсвэргүй шингэн ба хатуу бодис. Энэ тодорхойлолтонд тэсрэмтгий бодис, органик хэт исэл болон исэлдүүлэгч бодисууд хамаарахгүй

Өөрөө халдаг бодис буюу хольц - пирофор шингэн болон хатуу бодисоос бусад агаартай хүрэлцэх үед ямар нэг энергийн үйлчлэлгүйгээр аяндаа халдаг бодис хольц. Өөрөө халдаг бодис буюу хольц нь их хэмжээтэйгээр (килограммаар) удаан хугацааны (хэдэн цаг, хэдэн хоног) дараа гал авалцдаг хатуу, шингэн бодис ба хольцоос ялгаатай.

Пиротехникийн бодис (эсвэл хольц) гэж аяндаа экзотермийн урвалд орон, тэсрэлтгүйгээр дулаан, гал, авиа, утаа эсвэл эдгээрийн цогцыг үзүүлбэр маягаар гаргах зориулалттай бодис.

Пиротехникийн бүтээгдэхүүн гэж нэг буюу түүнээс дээш пиротехникийн бодис эсвэл тэдгээрийн хольцыг агуулсан бүтээгдэхүүн.

Пирофор шингэн - Бага хэмжээтэй байлаа ч агаартай хүрэлцэнгүүт таван минутын дотор гал авалцах чадвартай шингэн.

Пирофор хатуу бодис - бага хэмжээтэй байлаа ч агаартай хүрэлцэнгүүт таван минутын дотор гал авалцах чадвартай хатуу бодис.

Сэрэмжлүүлэх тэмдэглэгээ - аливаа аюултай бүтээгдэхүүнийг буруу хадгалах болон түүнтэй буруу харьцснаас үүсэж болох сөрөг үр дагаврыг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг заасан хэллэг.

Тэсрэмтгий бодис (хольц) гэж орчны юмсыг гэмтээх хэмжээний хурд, даралт, температур бүхий хий ялгаруулдаг химийн урвалд өөрөө орох чадвар бүхий хатуу, шингэн бодис (эсвэл бодисын хольц). Пиротехникийн бодис нь хий ялгаруулахгүй байсан ч энэхүү ангилалд хамаарна.

Тэсрэмтгий бүтээгдэхүүн гэж нэг болон хэд хэдэн тэсрэх бодис эсвэл хольц агуулсан бүтээгдэхүүн.

Устай харилцан үйлчлэхэд шатамхай хий ялгаруулдаг бодис буюу хольц- устай харилцан үйлчилмэгц өөрөө гал авалцдаг, эсвэл аюул учруулах хэмжээгээр шатамхай аюултай хий ялгаруулдаг хатуу ба шингэн бодис.

Ууссан хий – Даралтанд савлагдсан, шингэн уусгагчид ууссан хий.

Уур – хий дэх (ихэвчлэн агаар) бодис болон хольцын шингэн дусал.

Үр удамд нөлөөлөгч бодис- хүний үр хөврөлийн эсэд удамших өөрчлөлт оруулдаг бодис.

Хавдар үүсгэгч- хавдар үүсгэдэг, эсвэл түүний тохиолдлыг нэмэгдүүлдэг бодис, хольц.

Хайлш - Механик хэрэгслийн тусламжтайгаар салгах боломжгүйгээр нэгтгэсэн, хоёр болон түүнээс дээш элементээс тогтсон, макро түвшинд нэг төрлийн металл материал. НС-ийн хүрээнд тэдгээрийг хольцын төрөлд оруулж ангилдаг;

Хатуу бодис - Шингэн болон хий төлөвөөс бусад төлөвт оршиж буй бодис.

Хий -

1. 20⁰С-ийн температур ба 101,3 кПа абсолют даралтад хийн төлөвт орших бодис;
2. 50⁰С-ийн температурт 300 кПа-аас дээш абсолют даралтад уурын даралт үзүүлдэг бодис.

Химийн нэршил – Шинжлэх ухааны хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн, Онолын болон хавсарга химийн олон улсын холбоо (IUPAC) ба Химийн асуудлаар тойм бэлтгэх алба (CAS) –аас гаргасан нэршил;

Химийн бодисыг амьсгалах- шингэн болон хатуу бодис амаар болон хамраар дамжин мөгөөрсөн хоолой болон амьсгалын доод замын эрхтэн рүү шууд болон шууд бусаар буюу бөөлжих замаар орох.

Химийн тогтворгүй хий – агаар эсвэл хүчилтөрөгчийн оролцоогүйгээр ч тэсрэх урвалд орох чадвартай шатамхай хий.

Хольц – хоорондоо урвалд ордоггүй хоёр болон түүнээс дээш бодисоос бүрдсэн хатуу бодис эсвэл уусмал.

Хөргөж шингэрүүлсэн хий - Даралтанд савлагдсан, зарим хэсэг нь бага температурын улмаас шингэн төлөвт байгаа хий.

Худалдааны нэршил – Шинжлэх ухааны хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн, Онолын болон хавсарга химийн олон улсын холбоо ба Химийн асуудлаар тойм бэлтгэх албаас гаргасан нэршлээс гадна ихэвчлэн худалдаа, дүрэм, журам, хууль эрхийн актуудад бодис, хольцыг тодорхойлоход ашигладаг нэршил.

Шатамхай хатуу бодис – хялбар шатдаг эсвэл шатах шалтгаан болдог, эс бөгөөс үрэлтийн улмаас шатдаг хатуу бодис.

Шатамхай чанар – агаарт 20°C-ийн температур, 101.3 кПа абсолют даралтанд бодисын шатах боломж .

Шатамхай хий - 101,3 кПа хэвийн даралтанд, агаарын орчинд 20°C температурт гал авалцах чадвартай хий.

Шатах хязгаар - шатамхай хий эсвэл уурыг агаартай харьцуулсан харьцаа. Жишээлбэл: Тухайн шатамхай бодис агаар их байвал агаар тэнд бага байх бөгөөд энэ нь шаталт явагдах боломжтой гэж ойлгоно.

Шатамхай шингэн - Шатах температур нь 93°C-ээс бага байдаг шингэн.

Шахсан хий – Даралтанд савлагдсан, –50°C-д бүгд хийн төлөвт байгаа хий. Аюултай температур нь <-50°C байдаг бүх хий энэ төрөлд хамаарна.

Шингэн бодис - 50°C-ийн температурт 300 кПа (3 бар)-аас ихгүй уурын даралт үзүүлдэг бодис, хольц. Эдгээр нь:

1. 20°C-ийн температур, 101,3 кПа стандарт даралтад бүгд хийн төлөвт байдаггүй;
2. хайлах цэг ба хайлах эхний цэг нь 101,3 кПа стандарт даралтад 20°C-тэй тэнцүү болон түүнээс бага температурт байдаг бодис, хольц;
3. тодорхой хайлах цэггүй зууралдамхай бодис, хольц.

Шингэрүүлсэн хий – Даралтан дор -50°C-оос дээш температурт зарим хэсэг нь шингэн төлөвт орсон хий. Эдгээрийг: а/ Өндөр даралтын шингэрүүлсэн хий- аюултай температур нь -50°C-аас +65°C хооронд орших хий. б/Нам даралтын шингэрүүлсэн хий – аюултай температур нь +65°C-аас дээш орших хий гэж ялгадаг;

Шошго – Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүн агуулсан сав баглаа дээр тавигддаг, эсвэл сав, баглаа боодолд бэхлэгддэг, тухайн хортой, аюултай бүтээгдэхүүний талаар бичмэл болон дүрс хэлбэрээр илэрхийлсэн мэдээлэл;

ЕС₅₀ – Усны организмын 50%-д сөрөг нөлөө үзүүлж, өсөлт хөгжилтийг бууруулдаг тухайн бодисын усан дахь концентраци.

ЕС_х – урвалын х%-д хамаарах концентраци

LD₅₀ (үхлийн дундаж тун) – туршилтанд орсон амьтны 50% нь үхэлд хүрсэн нэг удаагийн тун.

LC₅₀ (үхлийн дундаж концентраци) –туршилтанд орсон амьтны 50% нь үхэлд хүргэсэн бодисын агаарт эсвэл усан дах концентраци.

K_{ow} – бодисын октанолд уусах чанарыг усанд уусах чанарт харьцуулсан харьцаа.

NOEC (No Observed Effect Concentration буюу нөлөөлөл өгөхгүй концентраци)- мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлэхгүй хамгийн доод концентраци.

5 ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН АНГИЛАЛ

5.1 АЮУЛТАЙ БОДИС

5.1.1 ТЭСРЭМТГИЙ БОДИС

Тэсрэмтгий бодис (хольц) гэж орчны юмсыг гэмтээх хэмжээний хурд, даралт, температур бүхий хий ялгаруулдаг химийн урвалд өөрөө орох чадвар бүхий хатуу, шингэн бодисыг (эсвэл бодисын хольц) хэлнэ. Пиротехникийн бодис нь хий ялгаруулахгүй байсан ч энэхүү ангилалд хамаарна.

Пиротехникийн бодис (эсвэл хольц) гэж аяндаа экзотермийн урвалд орон, тэсрэлтгүйгээр дулаан, гал, авиа, утаа эсвэл эдгээрийн цогцыг үзүүлбэр маягаар гаргах зориулалттай бодисыг хэлнэ.

Тэсрэмтгий бүтээгдэхүүн гэж нэг болон хэд хэдэн тэсрэх бодис эсвэл хольц агуулсан бүтээгдэхүүнийг хэлнэ.

Пиротехникийн бүтээгдэхүүн гэж нэг буюу түүнээс дээш пиротехникийн бодис эсвэл тэдгээрийн хольцыг агуулсан бүтээгдэхүүнийг хэлнэ.

Тэсрэмтгий бодисын ангилалд дараах бодис, бүтээгдэхүүн хамаарна.

- а) тэсрэмтгий бодис, тэдгээрийн хольц;
- б) тэсрэмтгий бүтээгдэхүүн (үүнд санамсаргүй гал авалцах, идэвхжих тохиолдолд гал, утаа, дулаан, их дуу чимээ болон цацралт зэрэг үзэгдэл гаргаж чадахааргүй хэмжээ бүхий тэсрэмтгий бодис юм уу хольцыг агуулсан багаж хэрэгсэл хамаарахгүй);
- в) дээрх а) ба б)-д дээр дурдагдаагүй боловч тэслэх ба пиротехникийн үзүүлбэрийн зориулалтаар үйлдвэрлэгдсэн, бодис, хольц ба бүтээгдэхүүн.

Тэсрэмтгий бодисын бүлэг

Тэсрэмтгий бодис, хольц, бүтээгдэхүүнийг учруулах аюулын төрлөөс нь хамааруулж дараах бүлэгт хуваана. Үүнд:

Тогтворгүй тэсрэмтгий бодис. Дулааны үйлчлэлд тогтворгүй буюу эсхүл хэвийн нөхцөлд тээвэрлэх, ашиглах болон түүнтэй харьцахад маш мэдрэмтгий бодис, хольц, бүтээгдэхүүн. Аюулгүй ажиллагааны тусгай арга хэмжээ авах шаардлагатай.

Бүлэг 1.1. Хүчтэй, өргөн цар хүрээ хамарсан тэсрэлт үүсгэх аюултай бодис, хольц, бүтээгдэхүүн (хүчтэй, өргөн цар хүрээ хамарсан тэсрэлт гэж тухайн орчинд байгаа бараг бүх ачаа бараанд агшин зуур нөлөөлөх тэсрэлтийг хэлнэ)

Бүлэг 1.2. Цохилтын хүч үүсгэх аюултай боловч хүчтэй тэсрэлт үүсгэдэггүй бодис, хольц, бүтээгдэхүүн;

Бүлэг 1.3. Галын аюултай болон бага хэмжээгээр дэлбэрэх, цохилтын хүч үүсгэдэг эсвэл аль алиныг нь зэрэг үүсгэх аюултай боловч хүчтэй өргөн хүрээг хамарсан тэсрэлт үүсгэдэггүй бодис, хольц, бүтээгдэхүүн:

1) шаталт нь их хэмжээний туяа дулаан ялгаралтыг нэмэгдүүлдэг, эсвэл

2) бие биенийхээ араас шатаж бага зэргийн дэлбэрэлт, цохилтын хүч үүсгэдэг эсвэл аль алиныг нь зэрэг үүсгэдэг.

Бүлэг 1.4. Бага хэмжээний тэсрэх аюултай бодис, хольц, бүтээгдэхүүн. Энэхүү дэд ангилалд гал авалцах эсвэл өдөөх үед бага зэргийн аюул үүсгэдэг бодис, хольц, бүтээгдэхүүн орно. Дэлбэрэлт нь сав баглаа боодлын дотор явагдах бөгөөд энэ үед хол зайд тарж цацагдахгүй ба гадна гарсан галаас сав баглаа боодолд агуулагдаж байгаа материалд агшин зуур дэлбэрэлт үүсэхгүй.

Бүлэг 1.5. Маш бага мэдрэмтгий боловч хүчтэй өргөн хүрээг хамран тэсрэх аюултай бодис, хольц, бүтээгдэхүүн. Хэдийгээр хүчтэй өргөн хүрээг хамрах тэсрэх аюултай бодис, хольц, бүтээгдэхүүн боловч мэдрэмтгий чанар маш багатай тул ердийн нөхцөлд өдөөлт болон гал авалцсанаас дэлбэрэлт үүсэх магадлал маш багатай.

Бүлэг 1.6. Туйлын бага мэдрэмтгий бөгөөд хүчтэй тэсрэх аюулгүй бодис, хольц, бүтээгдэхүүн. Энэхүү дэд ангилалд хамаарах бүтээгдэхүүн нь зөвхөн тэсрэлтэд туйлын мэдрэмж муутай бодис, хольц агуулах тул аюул ослын үед өдөөгдөх, дэлбэрэлт түгэх магадлал туйлын багатай.

Аюулын талаарх мэдээлэл

Тэсрэмтгий бодисын шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Тогтворгүй тэсрэмтгий бодис	Бүлэг 1.1	Бүлэг 1.2	Бүлэг 1.3	Бүлэг 1.4	Бүлэг 1.5	Бүлэг 1.6
Анхааруулах тэмдэг	Тэсэрч буй бөмбөг	Тэсэрч буй бөмбөг	Тэсэрч буй бөмбөг	Тэсэрч буй бөмбөг	Тэсэрч буй бөмбөг; эсвэл улбар шар хүрээнд 1.4 гэсэн тоо	Улбар шар хүрээнд 1.5 гэсэн тоо	Улбар шар хүрээнд 1.6 гэсэн тоо
Дохио үг	Аюултай	Аюултай	Аюултай	Аюултай	Анхаар	Аюултай	Дохио үг шаардлагагүй
Аюулын тэмдэглэгээ	Тогтворгүй тэсрэмтгий бодис	Тэсрэмтгий; хүчтэй тэсрэлт үүсгэх аюултай	Тэсрэмтгий; хүчтэй цохилтын хүч үүсгэх аюултай	Тэсрэмтгий; галын, дэлбэрэх болон цохилтын хүч үүсгэх аюултай	Галын болон цохилтын хүч үүсгэх аюултай	Галын аюулын үед хүчтэй дэлбэрэлт үүснэ	Аюулын тэмдэглэгээ шаардлагагүй

5.1.2 ШАТАМХАЙ ХИЙ (ХИМИЙН ТОГТВОРГҮЙ ХИЙ ОРНО)

Шатамхай хий (дэд ангилал 2.1.1) гэж 20⁰ С-ийн температур, 101,3 кПа-ийн ердийн даралтанд агаартай харилцан үйлчилснээр гал авалцдаг хийг хэлнэ.

Химийн тогтворгүй хий гэж агаар эсвэл хүчилтөрөгчийн оролцоогүйгээр ч тэсрэх урвалд ордог шатамхай хийг хэлнэ.

Шатамхай хийн зэрэглэл

Шатамхай хийг доорх зэрэглэлээр ангилна.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
1	20 ⁰ С-ийн температур, 101,3 кПа-ийн ердийн даралтанд байгаа хий: а/ агаарт эзлэхүүний 13% болон түүнээс бага хувийн хольц үүсгэхэд гал авалцдаг хий. б/ доод шатах хязгаараас үл хамааран, агаартай шатах хязгаар нь хамгийн багадаа 12 хувь байдаг хий
2	20 ⁰ С-ийн температур, 101,3 кПа-ийн ердийн даралтанд агаартай холилдоход шатамхай хязгаар үүсгэдэг зэрэглэл 1-д ороогүй бусад хий

Шатамхай хийг химийн тогтворгүй хий гэж үзэн, нэмэлтээр химийн тогтворгүй хийн ангиллын доорх 2 зэрэглэлийн аль нэгд хамааруулан ангилна.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
А	20 ⁰ С-ийн температур, 101,3 кПа-ийн ердийн даралтанд химийн тогтворгүй байдаг шатамхай хий
В	20 ⁰ С-аас дээш температур, 101,3 кПа-аас дээш даралтанд химийн тогтворгүй байдаг шатамхай хий

Аюулын талаарх мэдээлэл

Шатамхай хийн шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Шатамхай хий		Химийн тогтворгүй хий	
	Зэрэглэл 1	Зэрэглэл 2	А	В
Анхааруулах тэмдэг	Дөл	Анхааруулах тэмдэг шаардлагагүй	Нэмэлт тэмдэг шаардлагагүй	Нэмэлт тэмдэг шаардлагагүй
Дохио үг	Аюултай	Анхаар	Нэмэлт дохио үг шаардлагагүй	Нэмэлт дохио үг шаардлагагүй
Аюулын тэмдэглэгээ	Онцгой шатамхай хий	Шатамхай хий	Агааргүй орчинд ч тэсрэх аюултай	Температур, даралт нэмэгдэхэд агааргүй орчинд ч тэсрэх аюултай

5.1.3 АЭРОЗОЛ

Аэрозол буюу **аэрозолийн тоосруулагч** гэж дотроо шингэрүүлсэн болон даралтад уусгасан хийг шингэн, өтгөн зуурмаг, нунтагтай хольсон болон холиогүй хэлбэрээр агуулсан металл, шил, хуванцар материалаар хийсэн, дахин дүүргэн ашиглах боломжгүй, агуулсан

зүйлээ хатуу болон шингэний жижиг хэсэг агуулсан хий, суспенз, хөөс, зуурмаг, нунтаг, шингэн хэлбэрээр цацах хэрэгсэл бүхий савыг хэлнэ.

Аэрозолын ангилал

Аэрозолыг шатамхай чанар болон шаталтаас үүсэх дулаанаас хамааруулж 3 зэрэглэлээр ангилна.

Шаталтын дулаан нь хамгийн багадаа 20кДж/г-аас их шатамхай хий, шатамхай шингэн, шатамхай хатуу бодисыг 1%-аас их хмжээгээр агуулсан байвал 1 ба 2 дугаар зэрэглэлд орно. Шаталтын дулаан нь 20кДж/г-аас бага, шатамхай бодисыг 1%-аас багаар агуулсан бол 3 дугаар зэрэглэлд хамаарна.

Аюулын талаарх мэдээлэл

Аэрозолийг шатамхай чанар болон шаталтаас үүсэх дулаанаас нь хамааруулж 3 зэрэглэлд ангилна.

Аэрозолийн шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Зэрэглэл 1	Зэрэглэл 2	Зэрэглэл 3
Анхааруулах тэмдэг	Дөл	Тэмдэг шаардлагагүй	Тэмдэг шаардлагагүй
Дохио үг	Аюултай	Анхаар	Анхаар
Аюулын тэмдэглэгээ	Онцгой шатамхай аэрозол Даралтат сав: Халаавал тэсрэх аюултай байж болно	Шатамхай аэрозол Даралтат сав: Халаавал тэсрэх аюултай байж болно	Даралтат сав: Халаавал тэсрэх аюултай байж болно

5.1.4 ИСЭЛДҮҮЛЭГЧ ХИЙ

Исэлдүүлэгч хий гэж хүчилтөрөгч ялгаруулан агаараас илүүтэйгээр гал авалцуулах, эсвэл бусад материалын шаталтыг өдөөх чадвартай хийг хэлнэ.

Исэлдүүлэгч хийг нэг зэрэглэлд хамааруулна.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
1	хүчилтөрөгч ялгаруулан агаараас илүүтэйгээр гал авалцуулах, эсвэл бусад материалын шаталтыг өдөөх чадвартай аливаа хий.

Аюулын талаарх мэдээлэл

Исэлдүүлэгч хийн шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Зэрэглэл 1
Анхааруулах тэмдэг	Тойрог дээрх дөл
Дохио үг	Аюултай
Аюулын тэмдэглэгээ	Галын аюул үүсгэж, галыг өдөөж болзошгүй; исэлдүүлэгч

5.1.5 ДАРАЛТАД САВЛАСАН ХИЙ

Даралтад савласан хий гэж 200 кПа –аас багагүй даралтад савласан эсвэл 20°C-ээс дээш температуртай эсвэл шингэрүүлсэн эсвэл шингэрүүлж хөлдөөсөн хийг хэлнэ.

Эдгээрт шахсан хий, шингэрүүлсэн хий, ууссан хий болон хөлдөөж шингэрүүлсэн хийнүүд орно.

Даралтад савласан хийг савлах үед байсан физикийн төлөвөөр нь 4 бүлэг болгож ангилна.

Бүлэг	Шалгуур үзүүлэлт
Шахсан хий	Даралтанд савлах үед -50 °С-д бүгд хий төлөвт шилжсэн хий. Үүнд аюултай температур нь ≤ -50 °С байдаг бүх хий орно
Шингэрүүлсэн хий	Даралтанд савлах үед -50 °С-аас дээш температурт хэсэгчлэн шингэн төлөвт шилжсэн хий: а/өндөр даралттай шингэрүүлсэн хий: аюултай температур нь -50 °С –аас +65 °С-ийн хооронд байдаг хий, б/ нам даралттай шингэрүүлсэн хий: аюултай температур нь +65 °С –аас их хий
Хөлдөөж шингэрүүлсэн хий	Савлах үед нам температуртын улмаас хэсэгчлэн шингэн төлөвт шилжсэн хий
Ууссан хий	Даралтанд савлах үед шингэн уусгагчид ууссан хий

Аюулын талаарх мэдээлэл

Даралтад савласан хийн шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Шахсан хий	Шингэрүүлсэн хий	Хөлдөөж шингэрүүлсэн хий	Ууссан хий
Анхааруулах тэмдэг	Хийн цилиндр	Хийн цилиндр	Хийн цилиндр	Хийн цилиндр
Дохио үг	Анхаар	Анхаар	Анхаар	Анхаар
Аюулын тэмдэглэгээ	Даралтанд савласан хий. Халвал дэлбэрэх аюултай	Даралтанд савласан хий. Халвал дэлбэрэх аюултай	Хөлдөөсөн хий. Бага хэмийн түлэгдэлт эсвэл шархлаа үүсгэнэ	Даралтанд савласан хий. Халвал дэлбэрэх аюултай

5.1.6 ШАТАМХАЙ ШИНГЭН

Шатамхай шингэн гэж 93° С-аас бага температурт гал авалцдаг шингэнийг хэлнэ.

Шатамхай шингэнийг дараах зэрэглэлээр ангилна.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
1	Гал авалцах цэг нь <23 °С, буцлах эхний цэг нь ≤ 35 °С
2	Гал авалцах цэг нь <23 °С, буцлах эхний цэг нь >35 °С
3	Гал авалцах цэг нь ≥ 23 °С, буцлах эхний цэг нь ≤ 60 °С
4	Гал авалцах цэг нь >60 °С, буцлах эхний цэг нь ≤ 93 °С

Аюулын талаарх мэдээлэл

Шатамхай шингэний шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Зэрэглэл 1	Зэрэглэл 2	Зэрэглэл 3	Зэрэглэл 4
Анхааруулах тэмдэг	Дөл	Дөл	Дөл	Дөл
Дохио үг	Аюултай	Аюултай	Анхаар	Анхаар
Аюулын тэмдэглэгээ	Онцгой шатамхай шингэн ба уур	Их шатамхай шингэн ба уур	Шатамхай шингэн ба уур	Ноцомхой шингэн

5.1.7 ШАТАМХАЙ ХАТУУ БОДИС

Шатамхай хатуу бодис гэж хялбар шатдаг эсвэл үрэлтийн улмаас өөрөө шатдаг эсвэл шатаалтыг тэтгэдэг хатуу бодисыг хэлнэ.

Хялбар шатдаг хатуу бодис гэж асаж байгаа чүдэнз гэх мэт галын үүсвэртэй богино хугацаанд хүрэлцэхэд амархан шатаж, гал хурдан тархах аюултай нунтаг, үрлэн, зуурмаг хэлбэрийн бодисыг хэлнэ.

Шатамхай хатуу бодисыг дараах зэрэглэлээр ангилна.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
1	Шаталтын хурд тогтоох туршилт: Металлын нунтагаас бусад бодис, хольц: а/ нойтон бүс галыг зогсоох боломжгүй б/ шатах хугацаа < 45 сек эсвэл шатах хурд > 2.2мм/сек Металлын нунтаг: шатах хугацаа ≤ 5 мин
2	Шаталтын хурд тогтоох туршилт: Металлын нунтагаас бусад бодис, хольц: а/ нойтон бүс галыг хамгийн багадаа 4 минутанд барих боломжтой б/ шатах хугацаа < 45 сек эсвэл шатах хурд > 2.2мм/сек Металлын нунтаг: шатах хугацаа > 5 мин ба ≤10 мин

Аюулын талаарх мэдээлэл

Шатамхай хатуу бодисын шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Зэрэглэл 1	Зэрэглэл 2
Анхааруулах тэмдэг	Дөл	Дөл
Дохио үг	Аюултай	Анхаар
Аюулын тэмдэглэгээ	Шатамхай хатуу бодис	Шатамхай хатуу бодис

5.1.8 ӨӨРӨӨ УРВАЛД ОРДОГ БОДИС БА ХОЛЬЦ

Өөрөө урвалд ордог бодис ба хольц гэж хүчилтөрөгчийн (агаарын) оролцоогүй тохиолдолд ч экзотермийн эрчимтэй задралд ордог дулаанд тэсвэргүй шингэн ба хатуу бодисыг хэлнэ. Энэ тодорхойлолтонд тэсрэмтгий бодис, органик хэт исэл болон исэлдүүлэгч бодисууд хамаарахгүй.

Ангилал тогтоох шалгуур

Аливаа өөрөө урвалд ордог бодис ба хольц нь доорх тохиолдлоос бусад нөхцөлд энэ ангид хамаарна. Үүнд:

- а) тэдгээр нь тэсрэмтгий бодисын ангилалд хамаарч байгаа бол;
- б) тэдгээр нь исэлдүүлэгч шингэн ба хатуу бодисын ангилалд хамаарч байгаа бол;
- в) тэдгээр нь органик хэт ислийн ангилалд хамаарч байгаа бол;
- г) тэдгээрийн задралын дулаан 300 Дж/г-аас бага бол;
- д) эсвэл аяндаа хурдсах задралын температур нь (АХЗТ) 50 кг жинтэй баглаанд 75⁰ С-ээс их байвал;

Өөрөө урвалд ордог бодис ба хольцыг доорх төрлөөр ангилна. Үүнд:

а) аливаа өөрөө урвалд ордог бодис ба хольц нь баглаатай байхдаа тэсрэх буюу дефлаграцид (их хэмжээний дулаан ба гэрэл ялгаруулан шатах) хурдан ордог бол **А** төрлийн **өөрөө урвалд ордог бодист** хамрагдана;

б) тэсрэмтгий шинж чанартай аливаа өөрөө урвалд ордог бодис ба хольц нь баглаатай байхдаа тэсэрдэггүй, дефлаграцид хурдан ордоггүй боловч баглаандаа дулааны улмаас тэсрэх чадвартай байвал **В** төрлийн **өөрөө урвалд ордог бодист** орно;

в) тэсрэмтгий шинж чанартай аливаа өөрөө урвалд ордог бодис ба хольц нь баглаатай байхдаа тэсэрдэггүй, дефлаграцид хурдан ордоггүй ба дулааны улмаас тэсэрдэггүй бол **С** төрлийн **өөрөө урвалд ордог бодист** хамрагдана;

г) аливаа өөрөө урвалд ордог бодис ба хольц нь лабораторийн туршилтаар:

- i) хэсэгчлэн тэсэрдэг, дефлаграцид хурдан ордоггүй, битүү эзлэхүүнд халаахад эрчимтэй урвалд ордоггүй; эсвэл
- ii) тэсэрдэггүй, дефлаграцид аажмаар ордог, битүү эзлэхүүнд эрс түргэн урвалд ордоггүй; эсвэл
- iii) тэсэрдэггүй, дефлаграцид ордоггүй, битүү эзлэхүүнд халаахад дунд зэргийн дулааны үр нөлөө үзүүлдэг бол **Д** төрлийн **өөрөө урвалд ордог бодист** хамрагдана;

д) аливаа өөрөө урвалд ордог бодис нь лабораторийн туршилтаар тэсэрдэггүй, дефлаграцид ордоггүй, битүү эзлэхүүнд халаахад дулааны нөлөө сул үүсдэг буюу ямар ч нөлөө үзүүлэхгүй байвал **Е** төрлийн **өөрөө урвалд ордог бодист** хамрагдана;

е) аливаа өөрөө урвалд ордог бодис буюу хольц лабораторийн туршилтаар кавитацийн байдалд дэлбэрдэггүй, дефлаграцид ордоггүй, битүү эзлэхүүнд халаахад урвалын үр нөлөө султай, эсвэл ямар ч үр нөлөө үзүүлдэггүй, тэсрэлтийн үр нөлөө нь сул эсвэл огт байхгүй бол **F** төрлийн **өөрөө урвалд ордог бодист** хамрагдана.

ё) аливаа өөрөө урвалд ордог бодис буюу хольц лабораторийн туршилтаар кавитацийн байдалд дэлбэрдэггүй, дефлаграцид ордоггүй, битүү эзлэхүүнд халаахад ямар ч урвалын нөлөө үзүүлдэггүй, тэсэрдэггүй, дулааны үйлчлэлд тэсвэртэй (аяндаа хурдсах задралын температур нь 50 кг жинтэй баглаанд 60-75⁰ С байвал) ба шингэн хольцын хувьд мэдрэмтгий

бус болгохын тулд буцлах температур нь 150⁰ C-ээс дээш уусгагчийг ашигласан байвал **G** төрлийн **өөрөө урвалд ордог** бодист хамрагдана.

Аюулын талаарх мэдээлэл

Өөрөө урвалд ордог бодис ба хольцын шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	A төрөл	B төрөл	C ба D төрөл	E ба F төрөл	G төрөл
Анхааруулах тэмдэг	Тэсэрч буй бөмбөг	Тэсэрч буй бөмбөг ба дэл	Дөл	Дөл	Энэ ангилалд аюулын тэмдэг, тэмдэглэгээ шаардлагагүй
Дохио үг	Аюултай	Аюултай	Аюултай	Анхаар	
Аюулын тэмдэглэгээ	Халаавал тэсрэх аюултай	Халаавал галын эсвэл тэсрэх аюул үүсгэнэ	Халаавал галын аюул үүсгэнэ	Халаавал галын аюул үүсгэнэ	

5.1.9 ПИРОФОР ШИНГЭН

Пирофор шингэн гэж бага хэмжээтэй байлаа ч агаартай хүрэлцэнгүүт таван минутын дотор гал авалцах чадвартай шингэнийг хэлнэ.

Пирофор шингэний ангилал нь нэг зэрэглэлтэй.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
1	Идэвхгүй зөөгч дээр шингэнийг нэмж агаарт тавихад 5 минутын дотор гал авалцана, эсвэл шүүлтүүрийн цаасанд шингээж агаарт тавихад 5 минутын дотор гал авалцах буюу нүүрсжинэ.

Аюулын талаарх мэдээлэл

Пирофор шингэний шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Зэрэглэл 1
Анхааруулах тэмдэг	Дөл
Дохио үг	Аюултай
Аюулын тэмдэглээ	Агаартай хүрэлцэхэд шууд гал авалцана

5.1.10 ПИРОФОР ХАТУУ БОДИС

Пирофор хатуу бодис гэж бага хэмжээтэй байлаа ч агаартай хүрэлцэнгүүт таван минутын дотор гал авалцах чадвартай хатуу бодисыг хэлнэ.

Пирофор хатуу бодисын ангилал нь нэг зэрэглэлтэй.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
----------	------------------

1	Хатуу бодис агаар хүрэлцэнгүүт 5 минутын дотор гал авалцана
---	-------------------------------------------------------------

Аюулын талаарх мэдээлэл

Пирофор хатуу бодисын шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Зэрэглэл 1
Анхааруулах тэмдэг	Дөл
Дохио үг	Аюултай
Аюулын тэмдэглээ	Агаартай хүрэлцэхэд шууд гал авалцана

5.1.11 ӨӨРӨӨ ХАЛДАГ БОДИС БА ХОЛЬЦ

Өөрөө халдаг бодис буюу хольц гэж пирофор шингэн болон хатуу бодисоос бусад агаартай хүрэлцэх үед ямар нэг энергийн үйлчлэлгүйгээр аяндаа халдаг бодис хольцыг хэлнэ. Өөрөө халдаг бодис буюу хольц нь их хэмжээтэйгээр (килограммаар) удаан хугацааны (хэдэн цаг, хэдэн хоног) дараа гал авалцдаг хатуу, шингэн бодис ба хольцоос ялгаатай.

Өөрөө халдаг бодис, хольцыг дараах зэрэглэлээр ангилна.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
1	25 мм-ийн шоо дөрвөлжин дээжийг 140° С-д туршихад эерэг үр дүн гарсан
2	<p>а) Хэрэв бодис буюу хольцыг 3м³-ээс дээш хэмжээтэйгээр савлах бол, 100 мм-ээс дээш хэмжээтэй шоо дөрвөлжин дээжийг 140°С-д туршихад эерэг дүн гарсан, 25 мм-ийн шоо дөрвөлжин дээжийг 140° С-д туршихад сөрөг үр дүн гарсан;</p> <p>б) Хэрэв бодис буюу хольцыг 450 л-ээс их хэмжээгээр савлах бол, 100 мм-ийн шоо дөрвөлжин дээжийг 140° С-д туршихад эерэг дүн, 25 мм-ийн шоо дөрвөлжин дээжийг 140° С-д туршихад сөрөг дүн, 100 мм-ийн шоо дөрвөлжин дээжийг 120° С-д туршихад эерэг дүн тус тус гарсан;</p> <p>с) 100 мм-ийн шоо дөрвөлжин дээжийг 140° С-д туршихад эерэг дүн, 25 мм-ийн шоо дөрвөлжин дээжийг 140° С-д туршихад сөрөг дүн, 100 мм-ийн шоо дөрвөлжин дээжийг 100° С-д туршихад эерэг дүн гарсан бол.</p>

Аюулын талаарх мэдээлэл

Өөрөө халдаг бодис ба хольцын шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Зэрэглэл 1	Зэрэглэл 2
Анхааруулах тэмдэг	Дөл	Дөл
Дохио үг	Аюултай	Анхаар
Аюулын тэмдэглээ	Өөрөө хална, шатах аюултай	Их хэмжээтэй байвал өөрөө хална; шатах аюултай

5.1.12 УСТАЙ ХАРИЛЦАН ҮЙЛЧЛЭХЭД ШАТАМХАЙ ХИЙ ЯЛГАРУУЛДАГ БОДИС БА ХОЛЬЦ

Устай харилцан үйлчлэхэд шатамхай хий ялгаруулдаг бодис буюу хольц гэж устай харилцан үйлчилмэгц өөрөө гал авалцдаг, эсвэл аюул учруулах хэмжээгээр шатамхай аюултай хий ялгаруулдаг хатуу ба шингэн бодисыг хэлнэ.

	Зэрэглэл 1	Зэрэглэл 2	Зэрэглэл 3
Анхааруулах тэмдэг	Дөл	Дөл	Дөл
Дохио үг	Аюултай	Аюултай	Анхаар
Аюулын тэмдэглээ	Ус харилцан үйлчилвэл өөрөө шатах аюултай шатамхай хий ялгаруулна	Ус харилцан үйлчилвэл шатамхай хий ялгаруулна	Ус харилцан үйлчилвэл шатамхай хий ялгаруулна

Ус
тай
харилцан
үйлчлэхэ
Д
шатамха
й хий

ялгаруулдаг бодис буюу хольцыг 3 зэрэглэлээр ангилна.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
1	Гадаад орчны температурт устай эрчимтэй урвалд орон өөрөө шатах чадвартай хий ялгаруулдаг, эсвэл гадаад орчны температурт устай хангалттай идэвхтэй урвалд орж 1 минутад 1 кг бодисоос 10 л буюу түүнээс дээш хэмжээний шатамхай хий ялгаруулах чадвартай аливаа бодис буюу хольц.
2	Гадаад орчны температурт устай хангалттай идэвхтэй урвалд орж 1 цагт 1 кг бодисоос 20 литр буюу түүнээс дээш хэмжээний шатамхай хий ялгаруулах чадвартай, гэхдээ шалгуур үзүүлэлт нь 1 дүгээр зэрэглэлд тэнцэхгүй аливаа бодис буюу хольц.
3	Гадаад орчны температурт устай аажмаар урвалд орж 1 цагт 1 литр буюу түүнээс дээш хэмжээний галын аюултай хий ялгаруулах чадвартай, гэхдээ шалгуур үзүүлэлтүүд нь 1 ба 2 дугаар зэрэглэлд тэнцэхгүй аливаа бодис буюу хольц.

Аюулын талаарх мэдээлэл

Устай харилцан үйлчлэхэд шатамхай хий ялгаруулдаг бодис буюу хольцын шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

5.1.13 ИСЭЛДҮҮЛЭГЧ ШИНГЭН

Исэлдүүлэгч шингэн гэж өөрөө шатамхай биш ч гэсэн ихэвчлэн хүчилтөрөгч ялгаруулснаар бусад материалд шаталт үүсгэдэг болон шаталтыг нь дэмждэг шингэнийг хэлнэ. Исэлдүүлэгч шингэнийг доорх зэрэглэлээр ангилна.

Аюулын талаарх мэдээлэл

Исэлдүүлэгч шингэний шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Зэрэглэл 1	Зэрэглэл 2	Зэрэглэл 3
Анхааруулах тэмдэг	Тойрог дээрх дөл	Тойрог дээрх дөл	Тойрог дээрх дөл
Дохио үг	Аюултай	Аюултай	Анхаар
Аюулын тэмдэглээ	Шатах эсвэл тэсрэх аюултай, хүчтэй исэлдүүлэгч	Галыг өдөөх аюултай; исэлдүүлэгч	Гал өдөөх аюултай; исэлдүүлэгч

5.1.14

ДҮҮЛЭГЧ ХАТУУ БОДИС

Исэлдүүлэгч хатуу бодис гэж өөрөө шатамхай биш ч гэсэн ихэвчлэн хүчилтөрөгч ялгаруулах замаар гал авалцуулах, эсвэл бусад материалын шаталтыг өдөөх чадвартай хатуу бодисыг хэлнэ.

Исэлдүүлэгч хатуу бодисыг доорх зэрэглэлээр ангилна.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлтүүд
1	Бодис буюу хольцыг 1:1 харьцаагаар (жингийн) целлюлозтой хольж туршилт хийх явцад аяндаа гал авалцаж байвал; эсвэл 1:1 харьцаагаар (жингийн) хольсон бодис ба целлюлозын хольцын даралт нэмэгдэх дундаж хугацаа нь 50 процентын хлорын хүчлийг целлюлозтой 1:1 харьцаагаар (жингийн) хольсон хольцын даралт нэмэгдэх дундаж хугацаанаас бага байвал;
2	1:1 харьцаагаар (жингийн) хольсон бодис ба целлюлозын хольцын даралт ихсэх дундаж хугацаа нь хлорат натрийн 40 процентын усан уусмалыг целлюлозын 1:1 харьцаагаар (жингийн) хольсон хольцын даралт ихсэх дундаж хугацаанаас бага буюу тэнцүү, гэхдээ шалгуур үзүүлэлт нь зэрэглэл 1-ийн үзүүлэлтэд тэнцэхгүй байвал;
3	Бодис буюу хольцыг 1:1 харьцаагаар (жингийн) целлюлозтой хольж туршилт хийхэд даралт ихсэх дундаж хугацаа нь 65 процентын азотын хүчлийн усан уусмалыг целлюлозтой 1:1 харьцаагаар (жингийн) хольсон хольцын даралт ихсэх дундаж хугацаанаас бага буюу тэнцүү, гэхдээ шалгуур үзүүлэлт нь зэрэглэл 1 ба 2-ын үзүүлэлтэд тэнцэхгүй байвал;
Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
1	Бодис буюу хольцыг 4:1, эсвэл 1:1 харьцаагаар (жингийн) целлюлозтой холиход шатах дундаж хугацаа нь бромт калийг целлюлозтой 3:2 (жингийн) харьцаагаар хольсон хольцын шатах дундаж хугацаанаас бага байвал
2	Бодис буюу хольцыг 4:1, эсвэл 1:1 харьцаагаар (жингийн) целлюлозтой холиход шатах дундаж хугацаа нь бромт натрийг целлюлозтой 2:3 (жингийн) харьцаагаар хольсон хольцын шатах дундаж хугацаанаас бага буюу тэнцүү, гэхдээ зэрэглэл 1-ийн шалгуур үзүүлэлтэд тэнцэхгүй байвал
3	Бодис буюу хольцыг 4:1, эсвэл 1:1 харьцаагаар (жингийн) целлюлозтой холиход шатах дундаж хугацаа нь бромт калийг целлюлозтой 3:7 (жингийн) харьцаагаар хольсон хольцын шатах дундаж хугацаанаас бага буюу тэнцүү, гэхдээ зэрэглэл 1 ба 2-ийн шалгуур үзүүлэлтэд тэнцэхгүй байвал;

Аюулын талаарх мэдээлэл

Исэлдүүлэгч хатуу бодисын шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Зэрэглэл 1	Зэрэглэл 2	Зэрэглэл 3
Анхааруулах тэмдэг	Тойрог дээр дөл	Тойрог дээр дөл	Тойрог дээр дөл
Дохио үг	Аюултай	Аюултай	Анхаар
Аюулын тэмдэглээ	Шатах эсвэл тэсрэх аюултай, хүчтэй исэлдүүлэгч	Галыг өдөөх аюултай; исэлдүүлэгч	Гал өдөөх аюултай; исэлдүүлэгч

К ХЭТ ИСЭЛ

Органик хэт исэл гэж нэг, эсвэл хоёр атом устөрөгч нь органик радикалаар халагдсан устөрөгчийн хэт ислийн уламжлал гэж үзэж болох, -0-0- гэсэн хоёр валенттай бүлэг агуулсан шингэн, эсвэл хатуу төлөвт байдаг органик бодисыг хэлнэ.

Органик хэт исэл гэсэн нэр томъёонд органик хэт ислүүдийн хольцыг хамруулдаг. Органик хэт ислүүд нь аяндаа хурдсан экзотермийн задралд ордог дулаанд тогтворгүй бодис буюу хольц байх ба доор дурьдсан шинж чанарын нэг болон хэд хэдийг агуулсан байна. Үүнд:

- а) задрахдаа тэсрэх чадвартай;
- б) хурдан шатах чадвартай;
- в) доргилт, эсвэл үрэлтэнд мэдрэмтгий;
- г) бусад бодистой аюул үүсгэх урвалд орох чадвартай.

Органик хэт ислийг доорх төрлийн аль нэгэнд хамааруулна. Үүнд:

а) сав баглаа боодолтой байхдаа тэсрэх, эсвэл хурдан дефлаграцид орох боломжтой органик хэт исэл нь **А төрлийн органик хэт исэлд** багтана.

б) тэсрэмтгий шинж чанартай органик хэт исэл нь сав баглаа боодолтой байхдаа тэсрэх, эсвэл хурдан дефлаграцид ордоггүй ч, дулааны нөлөөгөөр тэсрэх боломжтой байвал **В төрлийн органик хэт исэлд** багтана.

в) тэсрэмтгий шинж чанартай органик хэт исэл буюу хольц нь сав баглаа боодолтой байхдаа тэсрэх, эсвэл хурдан дефлаграцид ордоггүй, дулааны нөлөөгөөр тэсэрдэггүй байвал **С төрлийн органик хэт исэлд** багтана.

г) Аливаа органик хэт исэл лабораторийн туршилтын явцад:

- I. хэсэгчлэн тэсэрдэг, хурдан дефлаграцид ордоггүй, битүү эзлэхүүнд халаахад эрчимтэй урвалд ордоггүй;
- II. тэсэрдэггүй, дефлаграцид удаан ордог, битүү эзлэхүүнд халаахад эрчимтэй урвалд ордоггүй;
- III. тэсэрдэггүй буюу дефлаграцид огт ордоггүй, битүү эзлэхүүнд халаахад дунд зэргийн урвалд ордог байвал **Д төрлийн органик хэт исэлд** багтана.

д) органик хэт исэл нь лабораторийн туршилтын явцад тэсэрдэггүй, дефлаграцид ч ордоггүй, битүү эзлэхүүнд халаахад урвалд муу ордог эсвэл огт ордоггүй байвал **Е төрлийн органик хэт исэлд** багтана.

е) органик хэт исэл нь лабораторийн туршилтын явцад кавитацийн төлөв байдалд тэсэрдэггүй, дефлаграцид огт ордоггүй, битүү эзлэхүүнд урвалд муу ордог эсвэл ордоггүй, мөн тэсрэх шинж багатай буюу огт байхгүй бол **Ф төрлийн органик хэт исэлд** багтана.

ё) органик хэт исэл нь лабораторийн туршилтын явцад кавитацийн төлөв байдалд тэсэрдэггүй, дефлаграцид огт ордоггүй, битүү эзлэхүүнд халаахад урвалд ордоггүй, мөн тэсэрдэггүй, дулаанд тэсвэртэй (аяндаа хурдсах задралын температур нь 50 кг жинтэй баглаанд 60° С буюу түүнээс байвал) байвал, мөн түүнчлэн шингэн хольцыг 150° С-ээс доошгүй буцлах температуртай шингэлэгч ашиглан мэдрэмтгий бус болгосон бол **G төрлийн органик хэт исэлд** багтана. Хэрэв органик хэт исэл нь дулаанд тогтвортой, шингэн хольцыг 150° С-ээс доош буцлах температуртай шингэлэгч ашиглан мэдрэмтгий бус болгосон бол уг бодис нь **F төрлийн органик хэт исэлд** багтана.

Аюулын талаарх мэдээлэл

Органик хэт ислийн шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	А төрөл	В төрөл	С ба D төрөл	Е ба F төрөл	G төрөл
Анхааруулах тэмдэг	Тэсэрч буй бөмбөг	Тэсэрч буй бөмбөг ба дөл	Дөл	Дөл	Энэ ангилалд аюулын тэмдэг, тэмдэглэгээ шаардлагагүй
Дохио үг	Аюултай	Аюултай	Аюултай	Болгоомжил	
Аюулын тэмдэглэгээ	Халаавал тэсрэх аюултай	Халаавал галын болон тэсрэх аюул үүсгэнэ	Халаавал галын аюул үүсгэнэ	Халаавал галын аюул үүсгэнэ	

5.1.16 МЕТАЛЛ ЗЭВРҮҮЛЭГЧ БОДИС

Металл зэврүүлэгч бодис, хольц гэж химийн урвалын нөлөөгөөр металлыг мэдэгдэхүйц хэмжээгээр гэмтээдэг эсвэл бүр устгадаг бодис буюу хольцыг хэлнэ.

Металл зэврүүлэгч бодис буюу хольц нь нэг зэрэглэлд хамаарна.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
1	Хөнгөн цагаан, эсвэл ган гадаргуугийн идэгдэлтийн (зэврэлтийн) зэрэг нь туршилтын температур 55° С-д нэг жилийн хугацаанд 6,25 мм-ээс дээш байна.

Аюулын талаарх мэдээлэл

Металл зэврүүлэгч бодис буюу хольцын шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Зэрэглэл
Анхааруулах тэмдэг	Металл болон хүний гар руу 2 хуруу шилнээс асарч буй шингэн
Дохио үг	Анхаар
Аюулын тэмдэглэгээ	Металлыг зэврүүлнэ

5.2 ХОРТОЙ БОДИС

5.2.1 ХОРТОЙ БОДИС

Хортой бодис гэж нэг тунг нэг удаа эсвэл хэд хэдэн тунг 24 цагийн туршид уух болон арьсаар, аль эсвэл 4 цагийн турш амьсгалах замаар биед орсны дараа хурц хордлого өгч, хортой үр дагавар үүсгэдэг бодисыг хэлнэ.

Тухайн бодисын LD₅₀ (амаар болон арьсаар) буюу LC₅₀ (амьсгалаар) гэж нэрлэгддэг нэгжээр илэрхийлэгдэх тоон шалгуур үзүүлэлтээр хортой бодисыг 5 зэрэглэлээр ангилна.

Өртөх зам	Зэрэглэл 1	Зэрэглэл 2	Зэрэглэл 3	Зэрэглэл 4	Зэрэглэл 5

Амаар (мг/кг биеийн жинг)	5	50	300	2000	5000
Арьсаар (мг/кг биеийн жинг)	50	200	1000	2000	
Хий (саяныг ⁻¹ /эзэлхүүн буюу ppm)	100	500	2500	5000	
Уур (мг/л)	0.5	2.0	10	20	
Тоосонцор ба мананцар (мг/л)	0.05	0.5	1.0	5	

Аюулын талаарх мэдээлэл

Хортой бодисын шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Зэргэлэл 1	Зэргэлэл 2	Зэргэлэл 3	Зэргэлэл 4	Зэргэлэл 5
Анхааруулах тэмдэг	Гавлын ба зөрүүлсэн чөмөгний яс	Гавлын ба зөрүүлсэн чөмөгний яс	Гавлын ба зөрүүлсэн чөмөгний яс	Анхаарлын тэмдэг	Анхааруулах тэмдэг шаардлагагүй
Дохио үг	Аюултай	Аюултай	Аюултай	Анхаар	Болгоомжил
Аюулын тэмдэглэгээ - амаар	Залгивал үхэлд хүргэнэ	Залгивал үхэлд хүргэнэ	Залгивал их хортой	Залгивал хортой	Залгивал хортой байж болно
- арьсаар	Арьсанд хүрвэл үхэлд хүргэнэ	Арьсанд хүрвэл үхэлд хүргэнэ	Арьсанд хүрвэл их хортой	Арьсанд хүрвэл хортой	Арьсанд хүрвэл хортой байж болно
-амьсгалах	Амьсгалвал үхэлд хүргэнэ	Амьсгалвал үхэлд хүргэнэ	Амьсгалвал их хортой	Амьсгалвал хортой	Амьсгалвал хортой байж болно

5.2.2 АРЬС ҮРЭВСҮҮЛЭГЧ БА ЦОЧРООГЧ БОДИС

Арьсны үрэвсэх гэдэг нь арьсанд үүсэн нөхөн сэргээгдэхгүй гэмтэл үүсэхийг хэлнэ. Өөрөөр хэлвэл 4 цагаас их хугацаагаар туршилтын бодисоор үйлчлэхэд арьсны өнгөн хэсгээр дамжин арьсны гүн рүү орсон илэрхий үхжил үүсэхийг хэлнэ. Энэ үед арьс эхлээд шархлах, цус гоожих, тав үүсэх, дараа нь 14 хоногийн ажиглалтын төгсгөлд арьс цайрч өнгөө алдан, сорви үүснэ.

Арьсны цочролт гэдэг нь 4 цагаас илүүгүй хугацаанд туршилтын бодисоор үйлчлэхэд арьсанд нөхөн сэргээгдэх гэмтэл үүсэхийг хэлнэ.

Арьс үрэвсүүлэгч бодис нь 1 зэрэглэлээр ангилагдах бөгөөд тухайн бодисын талаар хангалттай мэдээлэл байвал доорх 3 дэд зэрэглэлийн аль нэгд хамааруулж ангилж болно.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
Зэрэглэл 1	Туршилтанд орсон амьтны хамгийн багадаа нэг амьтанд ≤ 4 цагийн хугацаагаар үйлчлэхэд арьсны өнгөн давхаргаас гүн хүртэл харагдахуйц үхжил үүсэх
Дэд зэрэглэл 1А	Туршилтанд орсон амьтны хамгийн багадаа нэг амьтанд 3 минут хүртлэх хугацаагаар үйлчилсний дараа 1 цаг хүртэл хугацаанд ажиглахад арьсны үрэвсэл илрэх
Дэд зэрэглэл 1В	Туршилтанд орсон амьтны хамгийн багадаа нэг амьтанд 3 минутаас 1 цаг хүртэлх хугацаагаар үйлчилсний дараа 14 хоног хүртэл хугацаанд ажиглахад арьсны үрэвсэл илрэх
Дэд зэрэглэл 1С	Туршилтанд орсон амьтны хамгийн багадаа нэг амьтанд 1 цагаас 4 цаг хүртэлх

	хугацаагаар үйлчилсний дараа 14 хоног хүртэл хугацаанд ажиглахад арьсны үрэвсэл илрэх
--	---------------------------------------------------------------------------------------

Арьс цочроогч доорх 2 зэрэглэлээр ангилна.

Зэрэглэл	Шалгуур үзүүлэлт
Цочроогч (Зэрэглэл 2)	(1) Арьсан дээр урвал явагдаж эхэлснээс хойш дараалсан 3 өдрийн турш аажмаар урвал явагдахад туршилтанд орсон 3 амьтны 2-т боолтыг авснаас хойш 24, 48 ба 72 цагийн дараа арьсны улайлт, хавдрын хувьд дундаж урвал нь ≥ 2.3 - < 4.0 -ийн хэмжээнд байх; эсвэл (2) Багаар бодоход 2 амьтанд 14 хоног үргэлжлэх ажиглалтын дараа үрэвсэл (үс зулгаралт, эвэршилт, эдийн хэт өсөлт, хогжролт) хадгалагдсаар байх; эсвэл (3) Нэг амьтан дээр химийн үйлчлэлтэй холбоотойгоор эерэг нөлөөлөл мэдэгдэхүйцээр илрэх, гэхдээ дээр заагдсан шалгуур үзүүлэлтээс бага хэмжээгээр.
Хөнгөн цочроогч (Зэрэглэл 3)	Арьсан дээр урвал явагдаж эхэлснээс хойш дараалсан 3 өдрийн турш аажмаар урвал явагдахад туршилтанд орсон 3 амьтны 2-т боолтыг авснаас хойш 24, 48 ба 72 цагийн дараа арьсны улайлт, хавдрын хувьд дундаж урвал нь ≥ 1.5 - < 2.3 хэмжээнд байх

Аюулын талаарх мэдээлэл

Арьс үрэвсүүлэгч ба цочроогч бодисын шошгоны тэмдэг, тэмдэглэгээ

	Зэрэглэл 1			Зэрэглэл 2	Зэрэглэл 3
	1 А	1 В	1 С		
Анхааруулах тэмдэг	Металл болон хүний гар руу 2 хуруу шилнээс асгарч буй шингэн	Металл болон хүний гар руу 2 хуруу шилнээс асгарч буй шингэн	Металл болон хүний гар руу 2 хуруу шилнээс асгарч буй шингэн	Анхаарлын тэмдэг	Анхааруулах тэмдэг байхгүй
Дохио үг	Аюултай	Аюултай	Аюултай	Анхаар	Анхаар
Аюулын тэмдэглэгээ	Арьс, нүдийг хүчтэй түлж, гэмтээнэ	Арьс, нүдийг хүчтэй түлж, гэмтээнэ	Арьс, нүдийг хүчтэй түлж, гэмтээнэ	Арьсыг цочрооно	Арьсыг хөнгөн цочрооно
